



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ОЛГОЖ БУЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ХҮССЭН БОЛОН ХҮРТЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ (2022-2023)

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ
ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

2024 он

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	2
Зургийн жагсаалт	2
Графикийн жагсаалт	3-4
Товчилсон үгийн жагсаалт	5
Хураангуй	6
Нэгдүгээр бүлэг. Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны анхдагч мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулсан байдал	7-8
1.1. Судалгааны ажлын зорилго, зорилт, хамрах хүрээ	7
1.2. Судалгааны арга зүй, үе шат	7
1.3. Судалгааны зохион байгуулалт ба тулгарсан бэрхшээл	7-8
1.4. Мэдээлэл цуглуулсан баримт бичгийн жагсаалт	8
Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн дэмжлэг олгох үйл явцад хийсэн шинжилгээ	9-44
2.1. Санхүүгийн дэмжлэг олгож буй хууль эрхзүйн үндэслэл ба зохицуулалт	9-14
2.2. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах процесс, иргэдийн бүрдүүлэх баримт бичигт хийсэн шинжилгээ	14-19
2.3. Санхүүгийн дэмжлэг олгосон талаарх өгөгдлийн шинжилгээний үр дүн	19-20
2.4. Санхүүгийн дэмжлэгт 2022-2023 онд хамрагдахаар ирүүлсэн төслийн тоон мэдээлэл ...	21-24
2.5. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2022-2023 онд шалгарсан төслийн болон төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	24-39
2.6. Эргэн төлөгдөхгүй санхүүгийн дэмжлэгт 2022-2023 онд шалгарсан төслийн болон төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	40-42
2.7. Санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа	42-43
2.8. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал	43-44
Гуравдугаар бүлэг. Судалгааны дүгнэлт, зөвлөмж	44-46

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Санхүүгийн дэмжлэгийг олгоход мөрдөж буй журмын мэдээлэл	09-10
Хүснэгт 2. Судалгааны ажлын хүрээнд судлах 2022 оны санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгүүдийн мэдээлэл	11-12
Хүснэгт 3. Судалгааны ажлын хүрээнд судлах 2023 оны санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгүүдийн мэдээлэл	12-14
Хүснэгт 4. Санхүүгийн дэмжлэг олгох процесс, бүрдүүлэх баримт бичиг	15-17
Хүснэгт 5. Санхүүгийн дэмжлэг олгогдсон оны мэдээлэл	19-20
Хүснэгт 6. БГД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн	37
Хүснэгт 7. БЗД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн	37
Хүснэгт 8. СБД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн	38
Хүснэгт 9. СХД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн	38
Хүснэгт 10. ДГА-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн	38
Хүснэгт 11. БГД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл	38
Хүснэгт 12. БЗД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл	38
Хүснэгт 13. СБД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл	39
Хүснэгт 14. СХД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл	39
Хүснэгт 15. ДГА-хугацаа хэтрэлтийн мэдээлэл	39
Хүснэгт 16. Санхүүгийн бус дэмжлэгийн мэдээлэл.....	42
Хүснэгт 17. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан байдал (зээлийн өмнөх)	42
Хүснэгт 18. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан байдал (зээлийн дараах)	43
Хүснэгт 19. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан байдал	43
Хүснэгт 20. Борлуулалтын дэмжлэгийн гүйцэтгэл	43

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Санхүүгийн дэмжлэгийн процесс	15
Зураг 2. Хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн мэдээлэл	18
Зураг 3. Санхүүгийн дэмжлэгийн ерөнхий үзүүлэлт	20

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Нийт хүсэлт гаргасан иргэд, хүйсээр	21
График 2. Нийт хүсэлт гаргасан иргэд, насаар	21
График 3. Нийт хүсэлт гаргасан иргэд, байршлаар	21
График 4. Нийт ирсэн төсөл, эдийн засгийн үйл ажиллагаа чиглэлээр	22
График 5. БГД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр	23
График 6. БГД хүсэлт гаргасан иргэн, насаар	23
График 7. БЗД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр	23
График 8. БЗД хүсэлт гаргасан иргэн, насаар	23
График 9. СБД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр	23
График 10. СБД хүсэлт гаргасан иргэн, насаар	23
График 11. СХД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр	24
График 12. СХД хүсэлт гаргасан иргэн, насаар	24
График 13. ДГА хүсэлт гаргасан иргэн, хүйсээр	24
График 14. ДГА хүсэлт гаргасан иргэн, насаар	24
График 15. Нийт төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр	24
График 16. Нийт төсөл хэрэгжүүлэгч, насаар	24
График 17. Нийт төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор	25
График 18. Нийт төсөл хэрэгжүүлэгч, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр	25
График 19. Нийт төсөл хэрэгжүүлэгч, хөгжлийн бэрхшээлийн төрөл	26
График 20. Нийт төсөл хэрэгжүүлэгч, хөгжлийн бэрхшээлийн шалтгаан	26
График 21. Нийт төсөл хэрэгжүүлэгч бизнесийн туршлага	26
График 22. Нийт төсөл хэрэгжүүлэгч ажлын байр	26
График 23. БГД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор	27
График 24. БГД төсөл хэрэгжүүлэгч, насаар	27
График 25. БГД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр	27
График 26. БГД ажлын байрны мэдээлэл	28
График 27. БГД бизнесийн туршлага	28
График 28. БГД хөгжлийн бэрхшээлийн төрлөөр	28
График 29. БГД хөгжлийн бэрхшээлийн шалтгаанаар	28
График 30. БГД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр	29
График 31. БЗД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор	29
График 32. БЗД төсөл хэрэгжүүлэгч, насаар	30
График 33. БЗД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр	30
График 34. БЗД ажлын байрны мэдээлэл	30
График 35. БЗД бизнесийн туршлага	30
График 36. БЗД хөгжлийн бэрхшээлийн төрлөөр	30
График 37. БЗД хөгжлийн бэрхшээлийн шалтгаанаар	30
График 38. БЗД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр	31
График 39. СБД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор	31
График 40. СБД төсөл хэрэгжүүлэгч, насаар	32
График 41. СБД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр	32
График 42. СБД ажлын байрны мэдээлэл	32
График 43. СБД бизнесийн туршлага	32
График 44. СБД хөгжлийн бэрхшээлийн төрлөөр	32
График 45. СБД хөгжлийн бэрхшээлийн шалтгаанаар	32
График 46. СБД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр	33
График 47. СХД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор	33
График 48. СХД төсөл хэрэгжүүлэгч, насаар	34
График 49. СХД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр	34
График 50. СХД ажлын байрны мэдээлэл	34

График 51. СХД бизнесийн туршлага	34
График 52. СХД хөгжлийн бэрхшээлийн төрлөөр	34
График 53. СХД хөгжлийн бэрхшээлийн шалтгаанаар	34
График 54. СХД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр	35
График 55. ДГА төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор	35
График 56. ДГА төсөл хэрэгжүүлэгч, насаар	36
График 57. ДГА төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр	36
График 58. ДГА ажлын байрны мэдээлэл	36
График 59. ДГА бизнесийн туршлага	36
График 60. ДГА хөгжлийн бэрхшээлийн төрлөөр	36
График 61. ДГА хөгжлийн бэрхшээлийн шалтгаанаар	36
График 62. ДГА төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр	37
График 63. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан багийн гишүүдийн тоо, нас, хүйсээр	40
График 64. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан багийн гишүүд, боловсролоор	40
График 65. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан багийн гишүүд, мэргэжлээр	41
График 66. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан баг, үйл ажиллагааны чиглэлээр	41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААЭС	Аж ахуй эрхлэлтийн сургалт
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗД	Засаг дарга
ИДС	Их дээд сургууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МБСБ	Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
Төсөл	ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБ	Хөгжлийн бэрхшээлтэй
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба
ХЭБ	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

ЕРӨНХИЙ МЭДЭГДЭЛ

ТУС ХЭВЛЭЛИЙГ ЗӨВХӨН ДОТООДЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН БЭЛТГЭВ.

Энэхүү тайланд “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн багаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдийг дэмжих зорилгоор олгодог жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг олгож буй процесст хийсэн шинжилгээ, дүгнэлтийг бататгах анхдагч мэдээллийг цуглуулан, боловсруулж холбогдох шинжилгээг хийснээр сайжруулах зөвлөмжийг тусгасан болно. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

Энэхүү мэдээлэл цуглуулалтын зорилго нь 2023 онд төслийн хүрээнд Системийн өөрчлөлт, инновацийн төвийн гүйцэтгэсэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төсөл сонгон шалгаруулах процессыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх, бизнес бойжуулах төвийн санал” судалгааны дүгнэлтүүдээс дараах дүгнэлтүүд нь бодит байдалтай хэр нийцэж байгаа, өөрчлөлт зайлшгүй хийх шаардлагатай болохыг нотлон харуулахад оршиж байна.

Тайлангийн нэгдүгээр бүлэгт энэхүү мэдээлэл цуглуулалтын ажлын зорилго, хамрах хүрээ, мэдээлэл цуглуулалтын аргазүй болоод тулгарсан бэрхшээл зэргийг дурдсан бол хоёрдугаар бүлэгт цуглуулсан мэдээллийг 3 дэд бүлэгт хуваан шинжилгээ хийн дүгнэлт боловсруулсан. Гуравдугаар бүлэгд нэгдсэн дүгнэлт болон уг зарим илүүлсэн асуудлуудад чиглэсэн зөвлөмж, саналыг боловсруулан тусгасан болно.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм.

Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНХДАГЧ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛ

1.1. Судалгааны ажлын зорилго, зорилт, хамрах хүрээ

ЗОРИЛГО: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй санхүүгийн дэмжлэг хүссэн болон хүртэгчдийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж дүгнэлт боловсруулан, холбогдох хууль журамд тусгах санал боловсруулах

ХАМРАХ ХҮРЭЭ: Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст 5 төрлийн (иргэдэд олгох санхүүгийн дэмжлэг, малгүй болон цөөн малтай малчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэг, шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг, ахмад мэргэжилтнүүдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг) санхүүгийн дэмжлэг хүсэж өргөдөл өгсөн иргэдийн мэдээлэл

1.2. Судалгааны арга зүй, үе шат

Дээр дурдсан байрлалуудад анхдагч мэдээллийн эх сурвалж дээр ажилласан ба тоон судалгааны аргыг ашиглан нийт 6 байрлалд 5 төрлийн санхүүгийн дэмжлэг авах хүсэлт гаргасан иргэдийн материал, тухайн иргэдийг үнэлж, дүгнэн шалгаруулах ажлын зохион байгуулж хэрэгжүүлсэн, ажлын хэсэг, албадын ажлын тайлан зэргээс мэдээллийг авсан. Мөн бодлогын баримт бичиг, төсвийн хуваарилалт, төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүгийн дэмжлэгийн холбогдох материалыг судалж танилцав. Эх баримтаас олдоогүй зарим мэдээллийг хоёрдогч эх сурвалж болох Хөдөлмөр эрхлэлтийн цахим портоал ejob.gov.mn, www.ehalamj.mn программаас нэвтрэх эрхээр хандаж цуглуулсан. Энэхүү судалгааг гүйцэтгүүлэгч захиалагч талаас чиглүүлэн өгсөн Ажлын даалгаврын хүрээнд, мөн төслийн зөвлөхүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хэд, хэдэн гол шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийж холбогдох дүгнэлтийг боловсруулсан ба уг дүгнэлтүүд дээр үндэслэн сайжруулах зөвлөмжийг бодлого боловсруулагч нарт зориулан гаргасан болно.

Судалгаа, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх ажлыг 4 үе шаттай зохион байгуулав.

- I үе шат: Батлагдсан баримт бичгээс мэдээлэл цуглуулах. Ингэхдээ судалгааны түүвэр болгон захиалагч талаас сонгосон хугацаа болох 2022-2023 онуудад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх зохицуулах үүрэг бүхий баримт

бичгүүдийг судалж, дээрх цаг хугацаанд тавигдсан шаардлага, хэрэгжилтийн үе шат зэргийг тодорхойлсны үндсэн дээр мэдээлэл цуглуулах агуулгын хүрээг тодорхойлсон.

- II үе шат: Хамрах хүрээний дагуу 6 байршилд ажиллаж, архивын баримтаас мэдээлэл цуглуулсан.
- III үе шат: Цуглуулсан мэдээллийг нэгтгэн боловсруулж, шинжилгээ хийхэд бэлтгэн нарийвчлан хүснэгтэд шивж оруулсан. Ажлын даалгаварт заасан үндсэн үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийн ажилласан.
- IV үе шат: Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гол ололтуудыг захиалагч тал болон бодлого боловсруулагчдад тайлагнан ажиллав.

1.3. Судалгааны зохион байгуулалт ба тулгарсан бэрхшээл

4 үе шаттайгаар мэдээллийг эх материалаас цуглуулахын тулд сонгогдсон 6 байршилд ажиллахаар ХХҮЕГ-аас албан бичиг хүргүүлсэн. Албан бичигт тусгагдсан хугацаагаар 2024 оны 10 сарын 1-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны хугацаанд ажиллахаар төлөвлөсөн. Газар, хэлтсүүдэд тус албан бичиг 2024 оны 10 дугаар сарын 16-нд хүргэгдсэн.

1. Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ-т 2024.10.16-22, 2024.11.05-08-ны өдрүүдэд
2. Дорноговь аймгийн ХХҮГ-т 2024.10.23-2024.10.25
3. Сүхбаатар дүүргийн ХХҮХ-т 2024.10.30-2024.11.04
4. Баянзүрх дүүргийн ХХҮХ-т 2024.11.11-2024.11.18
5. Баянгол дүүргийн ХХҮХ-т 2024.11.19-2024.11.25
6. Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газарт 2024.11.27-2024.11.29

Ийнхүү судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг дээр цаг хугацаанд гүйцэтгэсэн ба энэ явцад зарим нэг бэрхшээлүүд тулгарсан. Тухайлбал, эх материалууд байгууллагын архивт орсон учир 2-3 жилийн өмнөх архивласан материалыг олох, зарим байгууллага архивын материалууд олдохгүй байх асуудал гарч байв. Мөн тухайн байгууллагын тус өдрийн үйл ажиллагаа, ажилтнуудын ажлын зохион байгуулалт, архивын баримтын эмх цэгц гэх мэт зүйлээс шалтгаалан хагас өдөр болон 1-2 өдрөөр ажил хойшлогдож байсан ба шаардлагатай мэдээллийг зөвхөн архивын баримтаас олж авах боломжгүй байсан бөгөөд хөдөлмөр, халамжийн салбарт ашиглагдаж байгаа программуудад нэвтрэх нэр хүсэж нэвтрэх эрхээр хандан цуглуулсан.

1.4. Мэдээлэл цуглуулсан баримт бичгийн жагсаалт

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын удирдамж, жижиг зардал баталсан тушаал
- Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн тушаал
- Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, үнэлгээ
- Ирүүлсэн төслийн материал
- Шалгарсан төслийн материал
- Иргэний бүрдүүлсэн баримт бичиг
- Санхүүгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэсэн тушаал
- Санхүүгийн дэмжлэгийн гэрээ
- Батлан даагчийн гэрээ
- Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан
- Сургалт зохион байгуулсан сургалтын байгууллагын тайлан

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажилгүй иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжих зорилгоор олгосоор ирсэн эргэн төлөлтгүй болон төлөлттэй санхүүгийн дэмжлэгийг олгож буй үйл явц, хүсэлт гарган хүлээн авч буй иргэдэд учирч буй саад, бэрхшээл, тэдний бодит хэрэгцээ зэргийг тодорхойлох зорилгоор өнгөрсөн хугацаанд олгосон дэмжлэгүүдийн бодит гүйцэтгэлийг сөхөн харах хэрэгтэй болсон. Ингэхдээ тухайн цаг хугацаанд дэмжлэг үзүүлэгч талаас барьж байсан бодлого, мөрдөж байсан бодлого, тавигдаж байсан нөхцөл, шаардлагуудыг судалгааны мэдээллийн нэгэн сурвалж болгон дурдах нь зүйтэй юм.

2.1. Санхүүгийн дэмжлэг олгож буй хууль эрхзүйн үндэслэл ба зохицуулалт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байхаар заасан байдаг.

Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг 2002 оноос хойш Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журмаар зохицуулж ирсэн ба 2002-2021 онд нийт 4 удаа шинэчлэн баталсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн дэмжлэгийг олгоход мөрдөж буй журмын мэдээлэл

Батлагдсан он, тогтоолын дугаар	Журмын нэр	Зохион байгуулах байгууллага	Дамжуулан олгох байгууллага	Олгох хэмжээ	Хүү хувь	Эргэн төлөлтийн хугацаа
2002 оны МУЗГ-ын 43-р тогтоол	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам	ХЭА тодорхойлолт гаргана, Банк, ББСБ зээл олгохыг дангаараа шийднэ	Банк болон банк бус санхүүгийн байгууллага	10.0 сая төгрөг хүртэл	Тухайн банк, ББСБ-аас олгож байгаа зээлийн хүүгээс илүүгүй байна	12 сар
2006 оны МУЗГ-ын 166 дугаар тогтоол	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам	Аймаг, дүүргийн ХЭБ тодорхойлолт гаргана, Банк, ББСБ зээл олгохыг дангаараа шийднэ	Банк болон банк бус санхүүгийн байгууллага	10.0 сая төгрөг хүртэл	1.3	12 сар
2011 оны МУЗГ-ын 375-р тогтоол	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам	Аймаг, дүүргийн ХЭБ тодорхойлолт гаргана, Банк зээл олгохыг дангаараа шийднэ Санхүүгийн дэмжлэгийн энэ журмын 4-д заасны дагуу олгоно.	Банк	Малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид 5.0 хүртэл сая Нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд 10.0 хүртэл сая	Тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна	24 сар
2016 оны МУЗГ-ын 276-р тогтоол	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх,	Аймаг, дүүргийн ХЭБ, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан санал, тодорхойлолт гаргана,	Банк	Иргэнд 10.0 хүртэл сая Иргэдийн бүлгийн 1 гишүүнд 2.0 хүртэл сая	Тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна	24 сар

	санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам	Банк зээл олгохыг дангаараа шийднэ Санхүүгийн дэмжлэгийн энэ журмын 5-д заасны дагуу олгоно.		ААНБ-д 20.0 хүртэл сая		
2021 оны МУЗГ-ын 340-р тогтоол	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам	Жижиг зээлийг: Аймаг, дүүргийн ХЭБ-ын дарга дүгнэлт гаргана, Банк зээл олгохыг шийдвэрлэнэ. Санхүүгийн дэмжлэгийн энэ журмын 5-д заасны дагуу олгоно.	Банк	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчинд 10.0 хүртэл сая Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, гадаад улсад ажиллаж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 хүртэл сая Бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид 50.0 хүртэл сая	Тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байна	36 сар Үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 6 сар

Дээрх журмуудад жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад голлон анхаарсан бол харин санхүүгийн бус дэмжлэг, сургалт, аргазүйн зөвлөгөө зэрэг бизнесийг амжилттай хэрэгжихэд чухал нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдийг орхигдуулсан. 2021 оны МУЗГ-ын 340-р тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.15-д *Банкнаас жижиг зээл олгох шийдвэр гарсны дараа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээлдэгчид ажлын байр бий болгох, өргөтгөх, тогтвортой хадгалах, санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, уулзалтыг зохион байгуулж, аж ахуйн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллана гэж заасан.*

Шигтгээ 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд зарцуулсан дүнг 2023 онд хуваарилан гаргасан мэдээлэл

ХХҮЕГ-ын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн мэдээнд нийт төсвийн 1%-ийг ажил хайхад туслахад, 2%-ийг сургалт, ур чадварыг нэмэгдүүлэхэд, 2%-ийг хөдөлмөрлөх сонирхлыг нэмэгдүүлэхэд, 14%-ийг ажлын байрыг шууд дэмжихэд, 23%-ийг хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй хүмүүсийг дэмжихэд, 59%-ийг бизнес эрхлэхэд тусламж үзүүлэхэд зарцуулсан гэжээ.

Үүнээс харахад нийт сангийн 59 хувийг жижиг, зээл, санхүүгийн дэмжлэгийг олгоход зориулан төлөвлөж буй атал эдгээр шинэ болон өргөжин тэлж буй бизнесийг дэмжих тал дээр санхүүгийн бус зөвлөх үйлчилгээ, бойжуулах үйлчилгээнд ямар нэгэн төсөв хуваарилахгүй байгаа нь төлөвлөлтийн бодлогод өөрчлөлт хийх шаардлагатайг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг, Сайдын тушаалаар тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж, жишиг зардлыг батлан улсын хэмжээнд санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажилладаг.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрийг, зохион байгуулах нэгдсэн удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/43 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг тус тус баталсан.

Хүснэгт 2. Судалгааны ажлын хүрээнд судлах 2022 оны санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгүүдийн мэдээлэл

Хөтөлбөрийн нэр	Арга хэмжээний нэр	Хамрах хүрээ	Дэмжлэг, зээлийн хэмжээ	Эргэн төлөлтийн нөхцөл, зохион байгуулалт
Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох	<p>Иргэн: Ажилгүй иргэн; Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;</p> <p>Өрх: Хөдөө орон нутагт шилжин суурьших хүсэлтэй өрх; Малгүй болон цөөн малтай өрх;</p> <p>Аж ахуйн нэгж байгууллага: Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч; Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч;</p>	10.0 хүртэл сая	36 сар Эргэн төлөгдөх
	Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах		Санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн өмнө ба дараа зохион байгуулна	Цахим болон танхимаар нийт 3 хоног, олгохоос өмнө 1 хоног, олгосны дараа 2 хоног
	Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох		5.0 сая	36 сарын дотор эргэн төлөх 21 аймаг, алсын 3 дүүргийн хөдөлмөрийн чадвартай 18-45 насны 2-с доошгүй гишүүнтэй малгүй болон 150 хүртэл толгой бог малтай өрх
	Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох		Мал худалдан авах 4.0 хүртэл сая, нүүлгэлтийн зардал 50-500.0 мян төгрөг	24 сар Эргэн төлөгдөх
	Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт зохион байгуулах		Мах, сүү цагаан идээ, ноос, арьс шир боловсруулах гэх мэт сургалт	18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-с доошгүй гишүүнтэй, гэр бүлээрээ хөдөөд шилжин суурьших
	Борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх		6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно	Арга хэмжээний хуваарилсан нийт хөрөнгийн 8%-иас ихгүй санхүүжилтийг зарцуулна Аймаг, дүүргийн ХХҮГ/Х иргэн, ААНБ-ын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэг 2-ыг ажиллуулах, улсын хэмжээнд өндөр хандалттай 2 хүртэлх хувийн хэвшлийн цахим хуудастай хамтрах
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Шилдэг старт ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан МУ-ын иргэн;	10.0 сая Аймагт 1, дүүрэгт 2 шилдэг старт ап	Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал, санаачлага гаргаж, аж ахуй эрхлэх төсөл

		15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд;		боловсруулсан шилдэг Старт ап залуу, залуучуудын багт эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгоно
	Улсын хэмжээнд старт ап зохион байгуулах	МБСБ-ын суралцагчид, ИДС, МБСБ төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ дадлага, туршлагагүй ажил хайж буй залуучууд;	I байр 1 баг 20.0 сая II байр 2 баг 17.0 сая III байр 3 баг 15.0 сая	Эргэн төлөгдөхгүй Аймаг, дүүрэгт шалгарсан залуу, баг улсын хэмжээний старт ап-д давхардан хамрагдахгүй
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох	Иргэн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүн;	5.0-10.0 хүртэл сая	36 хүртэл сар 50% эргэн төлөх
	Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах		Санхүүгийн дэмжлэгт шалгарч хамрагдсан иргэн, ААНБ-д шаардлагатай тохиолдолд ААЭС-ыг зохион байгуулж болно	Шаардлагатай тохиолдолд борлуулалтын дэмжлэг үзүүлж болно
	Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг олгох		6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно	Үзэсгэлэн яармаг зохион байгуулна; Гадаадад зохион байгуулагдах үзэсгэлэн яармагт оролцоход нь дэмжлэг үзүүлнэ;
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг олгох	ХХҮГ/Х-т хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахмад мэргэжилтэн; Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан;	5.0 хүртэл сая	24 сарын дотор 100% эргэн төлөх 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх 5 үйл ажиллагааг, зохион байгуулах нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалаар тус тус баталсан.

Хүснэгт 3. Судалгааны ажлын хүрээнд судлах 2023 оны санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгүүдийн мэдээлэл

Үйл ажиллагааны нэр	Арга хэмжээний нэр	Хамрах хүрээ	Дэмжлэг, зээлийн хэмжээ	Эргэн төлөлтийн нөхцөл, зохион байгуулалт
Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ	Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг	Аж ахуй, бичил бизнес үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 30 ба түүнээс дээш насны иргэн; МБСБ-ын төгсөгчид:	5.0-10.0 хүртэл сая	Эргэн төлөгдөх нөхцөлтэй 36 сарын хугацаатай

	Малчдыг малжуулах	Малгүй болон цөөн малтай малчин өрх	5.0 хүртэл сая	Эргэн төлөгдөх нөхцөлтэй 36 сарын дотор 21 аймаг, алсын 3 дүүргийн малгүй болон богд шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийг хамруулах
	Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах	18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-с доошгүй гишүүнтэй, гэр бүлээрээ хөдөөд шилжин суурьшиж, 2-с доошгүй жил гэрээт малчнаар ажиллах нөхцөлийг зөвшөөрч хүсэлт гаргасан иргэн	Мал худалдан авах 4.0 хүртэл сая, нүүлгэлтийн зардал 150.0-500.0 мян төгрөг	Эргэн төлөгдөх нөхцөлтэй 24 сарын хугацаанд
	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан МУ-ын иргэн; 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд; МБСБ-ын суралцагчид, ИДС, МБСБ төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ дадлага, туршлагагүй ажил хайж буй залуучууд; Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх Оролцоо төслийн төгсөгчид;	Аймаг дүүрэгт 10.0 сая Улсын хэмжээнд I байр 1 баг 20.0 сая II байр 2 баг 17.0 сая III байр 3 баг 15.0 сая	Эргэн төлөх нөхцөлгүй
	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй ахмад настан	5.0 хүртэл сая	24 сарын хугацаанд эргэн төлөх
	Түрээсийн дэмжлэг үзүүлэх	ХЭДС-аас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэн	6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно	
	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх	ХЭДС-аас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэн	2 хүртэлх хувийн хэвшлийн худалдааны цахим хуудастай хамтарч ажиллах	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	Санхүүгийн дэмжлэг	Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхэлж, ажлын байр бий болгох зорилготой ХБИ болон ХБ-тэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа (давхар ажил эрхэлээгүй) хүн	5.0-10.0 хүртэл сая	36 сарын хугацаанд 50 хувийг эргэн төлөх
	Аж ахуй эрхлэлтийн сургалт (өмнөх ба дараах)	Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан хүн	Шаардлагатай тохиолдолд сургалтыг зохион байгуулна.	
	Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг	6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа	6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.	

		хөдөлмөр эрхлэгч ХБ-тэй хүн	Борлуулалтын дэмжлэгийг ХХҮЕГ, ХБХХЕГ, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дэмжлэг үзүүлнэ.
--	--	-----------------------------	---

2.2. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах процесс, иргэдийн бүрдүүлэх баримт бичигт хийсэн шинжилгээ

Тайлангийн энэ хэсэгт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдийн санаачилгыг дэмжих зорилгоор 2022-2023 онуудын санхүүгийн дэмжлэгийн олголт хэрхэн явагдсан, процесийн ямар алхмууд шаардлагатай болон орхигдож буй, иргэд болон дэмжлэгийг олгож буй албан хаагчдад тулгарч буй бэрхшээл, хийдлийг баримт нотолгоонд үндэслэн тодорхойлохыг зорьсон болно.

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол болон тухайн жилд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, жишиг зардлын хэмжээг баримтлан орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажилладаг. Нэгдсэн удирдамжид эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд зарцуулах нийт хөрөнгийн 70 хүртэл хувийг 4 дүгээр сард, үлдсэн 30 хувийг 9 дүгээр сард тус тус зарцуулахаар төлөвлөж, холбогдох арга хэмжээг зохион байгуулна гэж заасан байна.

2023 онд батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг төрөлжүүлэн баталсан, мөн нэгдсэн удирдамжид хуваарилагдсан төсвийг зарцуулахад анхаарах болон хориглосон асуудлыг тодорхой зааж, хүснэгтээр ойлгомжтой байдлаар оруулж өгсөн нь анхан шатанд ажиллаж буй албан хаагчдын ажлын ачаалал болон төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц болж өгсөн нь харагдаж байна.

Шигтгээ 2. Мэдээлэл цуглуулах явцад ХХҮГ/Х-ийн мэргэжилтнүүдээс авсан ярилцлага

ХХҮГ/Х-үүд нь санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан иргэдийн хамрах хүрэнээс шалтгаалан тухайн иргэн нь ажилгүй иргэн, малчин, ахмад настан мөн эсэх, муу зээлийн түүхтэй эсэх, түрээсийн гэрээтэй эсэх зэргийг шалгаж, нягтлахын тулд нэмэлт баримт бичгийг тэднээс шаарддаг байна.

Судалгааны баг: Судалгааг цуглуулах явцад архивын баримтад үдэгдсэн эх материалд иргэний мэдээлэл дутуу байгааг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд ашиглагдаж буй ejob.gov.mn, e-halamj.mn системээс шалгаж үзэхэд 2 программын иргэний мэдээлэл зөрүүтэй, анхан шатанд ажиллаж буй хорооны хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний бүртгэлээс түүврээр нягталж үзэхэд мөн зөрүүтэй байгаа зэрэг нь иргэний бүртгэлийг хийж, үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчид тухай бүр мэдээллийг шинэчилдэггүй, бүртгэлийг хөтөлдөггүй, бүртгэхгүй байгаа нь харагдаж байна. Хэрвээ бүртгэл мэдээллээ үнэн зөв бодит байдлаар нь бүртгэж, мэдээллийн дата бааз үүсгэдэг бол иргэдээс нэмэлтээр баримт бичиг бүрдүүлэн авах шаардлага байхгүй.

Нэгдсэн удирдамжийн дагуу санхүүгийн дэмжлэг зохион байгуулах арга хэмжээг дараах процессын дагуу аймаг, дүүргийн ХХҮГ/Х нэгдсэн байдлаар зохион байгуулж, байгууллагын цахим хуудас, сум, хороодын иргэний танхимаар дамжуулан мэдээллийг хүргэж ажиллаж байна. Мөн хороо, сумдаар иргэдтэй уулзалт зохион байгуулах хэлбэрээр мэдээллийг хүргэж ажилласан байна.

Зураг 1. Санхүүгийн дэмжлэгийн процесс



Хүснэгт 4. Санхүүгийн дэмжлэг олгох процесс, бүрдүүлэх баримт бичиг

Санхүүгийн дэмжлэгийн нэр	Хэрэгжүүлэх дараалал	Иргэний бүрдүүлэх баримт бичиг		
		Журамд ¹ зааснаар	Нэгдсэн удирдамжид ² зааснаар	Аймаг, дүүргийн ХХҮГ/Х
Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	Сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулж, шалгарсан иргэнтэй аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, дэмжлэгийг олгоно.	Журмын 5.5-д: Санхүүгийн дэмжлэг авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж дараах баримт бичгийг өөрийн харьяалах аймаг, дүүргийн ХЭБ, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд, эсхүл энэ журмын 5,4-т дурдсан төсөл, хөтөлбөрт заасан	1. Санхүүгийн дэмжлэг хүссэн тухай өргөдөл 2. Иргэний өөрийн болон хамтран ажиллах бусад иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбар 3. Аж ахуй, бичил бизнес эрхлэх үйл ажиллагааны төсөл, төлөвлөгөө	Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг ³ санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэн болон иргэний боловсруулсан төсөлд журам болон удирдамжид зааснаас гадна нэмэлт шалгуур, бичиг баримт шаардлагатай гэж үзсэн бол ажлын хэсгээр хэлэлцүүлэн шийдвэрлэж, хурлын гэмдэглэлээр

¹ 2021 оны МУЗГ-ын 340-р тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”

² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/54 дүгээр тушаал, 2023 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”

³ Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн газар, хэлтсийн даргын тушаалаар санхүүгийн дэмжлэгийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилдог.

		байгууллагад хүргүүлнэ. 1.Санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдөл 2.Иргэний өөрийн болон хамтран ажиллах бусад иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбар, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 3.Холбогдох чиглэлээр боловсруулсан төсөл 4.ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрийн хүрээнд шаардагдах бусад баримт бичиг		баталгаажуулан төсөл хүлээн авах зар мэдээллийг олон нийтэд мэдээлдэг. Судалгаанд хамрагдсан ХХҮГ/Х-үүд дараах байдлаар баримт бичгийг нэмэлтээр хүлээн авсан. 1.Хүсэлт хорооны ЗД-ын цохолттой байх 2.Хорооны тодорхойлолт 3.НДШ төлөлтийн лавлагаа сүүлийн 6 сараар 4.Мэргэжил, ур чадварыг тодорхойлох баримт бичиг, сургалтын байгууллагаас олгосон гэрчилгээний хуулбар 5.Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа 6.Түрээсийн гэрээний хуулбар 7.Борлуулалтын тооцоо хөтөлсөн баримт 8.Ажлын байрны зураг
Малчдыг малжуулах	Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сонгож, гэрээ байгуулж, дэмжлэгийг олгоно.		<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн дэмжлэг хүссэн тухай өргөдөл • 18-45 насны 2-с доошгүй гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар • Эргэн төлөлтийг тусгасан боловсруулсан төсөл, төлөвлөгөө 	1.Өрхийн гишүүний үнэмлэх, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар 2.Малын А данс 3.Сум, багийн Засаг даргын тодорхойлолт /ам бүл, оршин суугаа хаяг/
Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	-Аймаг, дүүргийн сум, хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан ажилтан гарааны бизнес эхлүүлэх зорилготой залуу, залуучуудын багт зарлан мэдээлж, бүргэнэ. -Мэргэжлийн байгууллага сургалт, арга хэмжээг зохион байгуулна. -Аймгийн ажлын хэсэг аймагт шилдэг Старт ап-ыг, нийслэлийн ажлын хэсэг дүүргүүдэд шилдэг Старт ап-ыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, дэмжлэгийг олгоно. -Шалгарсан залуу, залуучуудын багийн үйл ажиллагаа тогтворжиж, бизнесийн ашгаа хүртэж эхэлтэл менторуудтай хамтарч, гэрээний үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.		<ul style="list-style-type: none"> • Бүртгүүлэх • Өөрийн болон багийн гишүүний иргэний үнэмлэхийн хуулбар 	Нас таарч байвал нэмэлтээр материал шаарддаггүй. Google form-оор бүртгэлийг ихэвчлэн хийсэн байна.


<p>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг</p>	<p>Төсөлд хамрагдах хүсэлтэй ахмад настан оршин суух харьяаллын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэх</p>		<ul style="list-style-type: none"> • Төслийг хэрэгжүүлэх тухайн сум, хорооны ЗД-ын тодорхойлолт • Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт • Иргэний үнэмлэхийн хуулбар • Боловсруулсан төсөл төлөвлөгөө • Бусад шаардлагатай лавлагаа 	<p>ХХҮГ/Х-ээс нэмэлтээр шаардсан баримт бичиг: 1.Хүсэлт хорооны ЗД-ын цохолттой байх 2.Тэтгэврийн дэвтрийн хуулбар 3.Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа 4.Мэргэжил, ур чадварыг тодорхойлох баримт бичиг, сургалтын байгууллагаас олгосон гэрчилгээний хуулбар 5.Ажлын байрны зураг</p>
<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох</p>	<p>4 сард багтаан, 8 сараас хойш зохион байгуулна. Зарласнаас хойш 21-28 хоногийн дотор, баримт бичиг хүлээн авснаар хойш ажлын 20 хоногийн дотор</p>		<ul style="list-style-type: none"> • Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хугацаа хүчинтэй бичиг баримт • Хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асарч байгаа хүн хүсэлт гаргах бол сум, хорооны ЗД-ын тодорхойлолт • Төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлт • Боловсруулсан төсөл, төлөвлөгөө 	<p>ХХҮГ/Х-ээс нэмэлтээр шаардсан баримт бичиг: 1.Түрээсийн гэрээ 2.Борлуулалт тооцоо хөтөлсөн баримт 3.НДШ төлөлтийн лавлагаа 4.Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа 5.ТҮЦ машинаас эсхүл и-монголиа системээс оршин суугаа газрын тодорхойлолт 6.Мэргэжил, ур чадварыг тодорхойлох баримт бичиг, сургалтын байгууллагаас олгосон гэрчилгээний хуулбар 7.Ажлын байрны зураг</p>

- Ерөнхийдөө санхүүгийн дэмжлэг олгох ажлыг зохион байгуулах үйл явц нь дээд удирдлага болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргаж өгсөн удирдамж, чиглэлийн дагуу зохион байгуулагдаж байна. Гэхдээ аймаг, дүүргийн түвшинд ажлын хэсэг байгуулах, төслийн материал хүлээн авахад тавигдах шаардлага, баримт бичгийн жагсаалт зэргийг шийдэж байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүд нь дээрээс өгсөн Нэгдсэн удирдамж болон журмын шаардлагаас гадна 1-7 хүртэлх нэмэлт баримтуудыг бичсэн төслийн хамтаар өгөхийг шаардсан байна. Эдгээр нэмэлт баримт, бичгүүдээс харахад хүсэлт гаргасан иргэдийн санхүүгийн чадавхи, зээлжих чадавхийг харах, баталгаа авах зорилгоор нэмэлт баримт бичгүүдийг шаардсан байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг, Сайдын тушаалаар тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж, жишиг зардлыг батлан улсын хэмжээнд санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өөрөөр хэлбэл бодлого, арга хэмжээ, удирдамж ямар батлагдана яг түүгээрээ анхан шатны нэгж дээр хэрэгждэг. Гэхдээ ирүүлсэн төслийг хэрхэн үнэлэх, сонгон шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг хэмжих тал дээр дэлгэрэнгүй, тодорхой чиглэл, зөвлөмж байдаггүйн улмаас бодит байдал дээр эрсдэл өндөр бизнесүүд дэмжлэг авах, олгосон нэгжүүд эргээд үр дүнгээ тооцох, эргэн төлөлтөө олж авах тал дээр асуудлууд үүсдэг.

- Дээрх зохицуулалтын журмуудад жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад голлон анхаарсан бол харин санхүүгийн бус дэмжлэг, сургалт, аргазүйн зөвлөгөө зэрэг бизнесийг амжилттай хэрэгжихэд чухал нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдийг орхигдуулсан.
- Дээрх бүрдүүлэх баримт бичигт төсөл, төлөвлөгөө гэж заасан нь хүсэлт өгч буй иргэдийн хувьд ч тэр хүлээж авч үнэлэх ажлын хэсгийн хувьд ч анхаарвал зохих гол асуудал болж байна. Санхүүгийн дэмжлэг авах хүсэлтэй иргэд нэг өдрийн сургалтад хамрагдаж хэрхэн төсөл бичих талаар анхны ойлголт, мэдээлэл авдаг. Гэхдээ зарим иргэд төслүүдээ ямар нэг өөр мэргэжилтэн, эсвэл байгууллагаар бэлтгүүлэн бичүүлдэг тохиолдол байсаар байна. Бизнес эрхлэх ямар нэгэн туршлагатай анх эхэлж буй иргэдийн хувьд төсөл, төлөвлөгөө боловсруулах нь хүндрэлтэй байдаг ба энэ “төсөл, төлөвлөгөө” ямар бүтэц, агуулгатай байх талаар, жишиг загвар, чиглүүлэг байдаггүй.
- Дээрх дүүргүүд, аймагт ажиллаж, мэдээлэл цуглуулах явцад ХЭДС-с олгож буй санхүүгийн дэмжлэгийг зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс харахад асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс бүрдсэн байсан. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчид буюу нийгмийн үйлчилгээний чиг үүрэгтэй, туршлагатай хүмүүсээс бүрдсэн байгаа нь төсөл шалгаруулах үнэлгээг гүйцэтгэхэд төдийлөн оновчтой биш юм.
- 2022 онд НҮБХХ-ийн хэрэгжүүлсэн хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг өөрчлөх ажлын хүрээнд улсын хэмжээнд ажиллаж буй нийт хөдөлмөрийн албан хаагчдын судалгааг хийсэн байдаг. Уг судалгаагаанд нийт 352 мэргэжилтнийг хамруулсан бөгөөд мэргэжилтнүүдийн эзэмшсэн мэргэжлийг авч үзэхэд:

Зураг 2. Хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн мэргэжил

Эзэмшсэн мэргэжил



бизнесийн чиглэлээр мэргэшсэн хүн байгаагүй ба мөн нийт судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн 40 гаруй хувь нь уг албан тушаалдаа 1 хүрэхгүй жил ажлласан байсан. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажиллагсдын дунд тогвортой ажиллах хүчин бага байгааг харуулахаас гадна, хувиараа хөдөлмөр эрхлэхээр төрөөс дэмжлэг хүсэж буй иргэдийн чадавхийг үнэн зөв үнэлж, дэмжлэг олгох гэхээсээ илүү шаардлагад нийцсэн баримт бичиг ирүүлсэн эсэхэд үнэлгээ өгч шалгаруулж байна гэж хэлж болохоор байна.

- Судалгаагаар ажлын хэсэг төслийг хэрхэн ямар аргачлал, оноо өгч үнэлдэг мөн татгалзсан шалтгааны мэдээлэл авах боломжгүй, олдоогүй ба нийтлэг татгалзсан шалтгаан нь ажлын байр байхгүй, өөр хүний ажлын байр үзүүлсэн, төсөл шаардлага хангаагүй, бусад төсөлд давхар хамрагдсан, иргэн өөрөө шаардлага хангаагүй гэсэн тайлбарыг өгч байсан. Хассан шалтгаанаар сонгосон ажлын хэсэг бүртгэл, мэдээлэл хөтөлдөггүй байна.

2.3. Санхүүгийн дэмжлэгийн олгосон талаарх өгөгдлийн шинжилгээний үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2012 оноос туршилтын байдлаар, 2013 оноос Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг батлан хэрэгжүүлж ирсэн байна.

Хүснэгт 5. Санхүүгийн дэмжлэг олгогдсон оны мэдээлэл


Олгож эхэлсэн он	Санхүүгийн дэмжлэгийн хэлбэр
2012	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жижиг бизнесийн төслийг сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэг олгох • Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд санхүүгийн дэмжлэг олгох • Малжуулах санхүүгийн дэмжлэг /малчин өрх, залуу малчин/ • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох
2013	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд санхүүгийн дэмжлэг олгох • Залуу малчин өрх, малчин ажил олгогч, мал бүхий иргэдэд санхүүгийн дэмжлэг олгох • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох • 40-өөс дээш насны иргэдэд санхүүгийн дэмжлэг олгох
2014	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Аж ахуй эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох • Малжуулах • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох
2015	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох /хувиараа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх/ • Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох /ажлын байр хадгалах/ • Борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх • Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдөд дэмжлэг үзүүлэх • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох • Малжуулах • Малчдын бүлэгт багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх
2016	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох /хувиараа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх/ • Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох /ажлын байрыг дэмжих/ • Борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх • Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт дэмжлэг олгох • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох • Малжуулах
2017	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Иргэнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох /хувиараа болон нөхөрлөл, хоршоо хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч/ • Борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх

	<ul style="list-style-type: none"> • Ахмад настанд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох • Малжуулах /эргэн төлөгдөх/ • Гарааны бизнес эрхлэгч залуучуудад эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох
2018-2021	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Иргэнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох /хувиараа болон нөхөрлөл, хоршоо хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч/ • Ахмад настанд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох /2020 онд 50 хувь эргэн төлөлт/ • Малжуулах /эргэн төлөгдөх/ • Гарааны бизнес эрхлэгч залуучуудад эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох • Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх
2022	<ul style="list-style-type: none"> • Жижиг зээл • Иргэнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох /аж ахуй эрхлэгч/ • Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох • Ахмад настанд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох • Малжуулах /эргэн төлөгдөх/ • Гарааны бизнес эрхлэгч залуучуудад эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгох • Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг олгох • Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх

Судалгааны 6 цэгийн мэдээллийг хэд хэдэн үзүүлэлтээр задлан танилцуулсан бөгөөд өгөгдөлд шинжилгээ хийж судалгааны гол дүгнэлтүүдийг гаргасан болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2022-2023 онд 5 санхүүгийн дэмжлэгийн хүсэлт, олголт, эргэн төлөлтийн ерөнхий бүдүүвч дараах байдалтай байна.

Зураг 3. Санхүүгийн дэмжлэгийн ерөнхий үзүүлэлт



Судалгааны мэдээлэл цуглуулсан 2022-2023 онуудад дээрх 5 санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 3485 хүсэлт хүлээн авч 1789-д нь олгосон байна. Гэхдээ тухайн жилүүдэд эргэн төлөлтийн түвшин өмнөх жилүүдийн адил доогуур байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл жил бүр өндөр байдаг нь тухайн зээл олгох зорилтот бүлгээ хэт, ерөнхий тодорхойлсон, санхүүгийн дэмжлэгийн хүсэлтийг төрийн албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг үнэлдэг, 100 хувь эргэн төлөгдөх нөхцөл тавьдаг, өмнө нь бизнес эрхэлж байсан эсэх туршлагыг үл хамааран олгож буй зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлж байна⁴.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийн гүйцэтгэлийн мэдээлэл тайлан мэдээ нь хүний тоо, зарцуулсан хөрөнгө, ажлын байрны тоо гэсэн ерөнхий үзүүлэлтээр гардаг. Энэхүү судалгаагаар **санхүүжилт хүссэн иргэдийн** мэдээллийг хэд хэдэн үзүүлэлтээр мөн **дэмжлэг аваад үйл**

⁴ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төсөл сонгон шалгаруулах процессыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх, бизнес бойжуулах төвийн санал. Зөвлөх үйлчилгээний тайлан, Системийн өөрчлөлт, инновацийн төв, 2023 он.

ажиллагаагаа явуулж буй иргэдийн мэдээллийг дараах байдлаар цуглуулан нэгтгэн шинжилсэн болно.

2.4. Санхүүгийн дэмжлэгт 2022-2023 онд хамрагдахаар ирүүлсэн төслийн тоон мэдээлэл

График 1. Нийт хүсэлт гаргасан иргэд, хүйсээр






График 2. Нийт хүсэлт гаргасан иргэд, насаар



Санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт гаргаж буй иргэдийн хүйсийн хувьд эмэгтэйчүүд илүү давамгайлах байдал ажиглагдаж байна. Монгол банкнаас хийсэн Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа, Мянганы сорилтын сангийн хийсэн Хөрөнгийн эрхийн судалгаанд эмэгтэйчүүд бизнес эрхлэх, санхүүгийн аливаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд илүү хариуцлагатай ханддаг, идэвхтэй оролцдог талаар дурдсан байдаг ба санхүүгийн дэмжлэгийн хувьд мөн ижил дүр төрх ажиглагдаж байна.

Насны хувьд 2022 онд 35-44 насны залуучууд санхүүгийн дэмжлэгийг авах хүсэлт их гаргасан бол 45-54 насныхан мөн идэвхтэйгээр хүсэлт гаргасан байна. Энэ тоо 2023 онд харьцангуй буурсан нь санхүүгийн дэмжлэг олгох санхүүжилт хоцорсонтой холбоотойгоор бага хугацаанд зохион байгуулж цөөн хүнд мэдээлэл хүрсэн байх магадлалтай байна.


График 3. Нийт хүсэлт гаргасан иргэд, байршлаар



Байршлын хувьд үзвэл хүн ам хамгийн ихтэй дүүргүүдэд илүү олон иргэд хүсэлт гаргасан байгаа нь тухайн жилийн ХЭДС-ийн санхүүжилтийн хуваарилалт нь хүн амын түвшинтэй уялдуулан төсвийг хуваарилснаас шалтгаалан хамрагдах хүний квотыг тогтоож өгч байгаатай холбоотой юм. Гэхдээ

үндсэн хүн амтай харьцуулахад санхүүгийн дэмжлэг хүсч байгаа иргэдтэй харьцуулахад харьцангуй бага байна. ХЭДС-аас хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж буй хөрөнгө үр ашигтай байсан. Бага зардлаар аль болох олон хүнийг хамруулахыг зорьсон байна.⁵

График 4. Нийт ирсэн төсөл, эдийн засгийн үйл ажиллагаа чиглэлээр



Үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл сүүлийн 2 жилийн хугацаанд боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр санхүүгийн дэмжлэг хүссэн иргэд зонхилж байсан ба хөдөө аж ахуйн чиглэлийн хүсэлд удаалж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс санхүүгийн дэмжлэг, жижиг зээл олгох эдийн засгийн чиглэлийг нарийвчлан заадаггүй ерөнхий мэдээлэл өгдөг учир иргэд өөрсдийн сонирхсон, туршлагажсан чиглэлээрээ төсөл бичдэг байна. Боловсруулах, ХАА-н чиглэл дотроо оёдол, гутал засвар, төмөр хийц, цайны газар зэрэг төслүүд дийлэнх нь байна. Ахмадад олгох санхүүгийн дэмжлэгийн хувьд оёдол, ногоон хүлэмжийн төслүүд голдуу дэмжигдсэн байна. Судалгааны мэдээлэл цуглуулсан 6 байршил тус бүрт санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт гаргасан иргэдийн мэдээллийг насны бүлэг, хүйсээр задлан харвал дараах байдалтай байна.

⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээний тайлан, UNDP 2023 он

График 5. БГД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр




График 6. БГД хүсэлт гаргасан иргэн, насаар




График 7. БЗД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр




График 8. БЗД хүсэлт гаргасан иргэн, насаар




График 9. СБД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр



График 10. СБД хүсэлт гаргасан иргэн, насаар




График 11. СХД хүсэлт гаргасан иргэн, хүйсээр



График 12. СХД хүсэлт гаргасан иргэн, насаар





График 13. ДГА хүсэлт гаргасан иргэн, хүйсээр



График 14. ДГА хүсэлт гаргасан иргэн, насаар



2.5. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2022-2023 онд шалгарсан төслийн болон төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Судалгаанд хамрагдсан нийт 4 дүүрэг, 1 аймгийн санхүүгийн дэмжлэг авсан иргэний мэдээллийг дараах үзүүлэлтээр задлан харвал:

График 15. Нийт төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр






График 16. Нийт төсөл хэрэгжүүлэгч, насаар




Төсөл нь шалгарсан иргэдийн мэдээллийг харвал мөн дийлэнх нь эмэгтэйчүүдийн төсөл илүү дэмжигдсэн бол насны бүлгийн хувьд 35-44, 45-54 насны иргэдийн төсөл шалгарч санхүүжилт аван үйл ажиллагаа явуулж байна. 55+ насны иргэдэд зориулсан санхүүгийн дэмжлэг олгогдож байгаа учраас нийт зээл авсан иргэдийн тоонд ахмад настны эзлэх хувь өндөр буюу 30% байна.

График 17. Нийт төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор



Нийт төсөл авч хэрэгжүүлж буй иргэдийн дийлэнх нь буюу 55 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байсан бол 19 хувь нь бакалаврын зэрэгтэй иргэд байна.

График 18. Нийт төсөл хэрэгжүүлэгч, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр



Хэрэгжүүлж буй төслүүдийг эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр нь харвал Боловсруулах үйлдвэрлэл 70 хувь, ХАА 13 хувь, 17 хувь нь бусад салбарт хэрэгжиж байна.

График 19. Төсөл хэрэгжүүлэгч, ХБ төрөл





График 20. Төсөл хэрэгжүүлэгч, ХБ шалтгаан



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгодог санхүүгийн дэмжлэгийн хувьд сэтгэцийн 20 хувь, сонсголын 10 хувь, хөдөлгөөний 16 хувь, харааны 10 хувийн бэрхшээлтэй иргэдэд дийлэнх төсөл олгогдсон бол бусад буюу өөр шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд буюу 44 хувьд санхүүгийн дэмжлэг олгожээ.

График 21. Төсөл хэрэгжүүлэгч бизнесийн туршлага





График 22. Төсөл хэрэгжүүлэгч ажлын байр



Санхүүгийн дэмжлэг авснаар бий болсон болон хадгалагдаж буй ажлын байрны мэдээллийг харахад ихэнх нь буюу 55 хувь нь тухайн ажлын байраа хадгалж, үлдэх үйл ажиллагаагаа тасалдуулахгүй

үргэлжлүүлэхэд зарцуулж байгаа бол 45 хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн шинэ ажлын байр гаргаж чадаж байна.

Түүнчлэн санхүүжилт авсан иргэдийн 53 хувь нь 5 хүртэл жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай буюу шинээр эхлээд удаагүй байгаа төслүүд байсан бол ажилласан жил нэмэгдэх тусам дэмжлэг авах нь бага болж, биеэ дааж, бизнес нь жигдэрсэн иргэдэд ХЭДС-ын дэмжлэг төдийлөн шаардлагатай бус болохыг харуулж байна.

Дэмжлэг авсан төслүүдийн дийлэнх нь тоног төхөөрөмж түүхий эд авах, бүтээгдэхүүнээ өргөжүүлэх зэрэг нийт төслийн зөвхөн тодорхой нэг хэсгийг л санхүүжүүлэхээр хүсэлт гаргаж байгаа нь иргэдийн гаргасан санаачилгыг бүхэлд нь санхүүжүүлж хүрэхгүй зөвхөн нэгэн хэсэгт зарцуулагдаж байгааг харж болохоор байна. Үүнээс хоёр дүгнэлт хийж болохоор байна. 1-т Санхүүжилтийн батлагдсан дээд дүн иргэдийн хэрэгцээг санхүүжилтэд хангалттай хүрэлцэхгүй байгаа эсвэл 2-т иргэд санхүүгийн мэдлэг муу учраас нийт санхүүжилтээ зөвхөн тодорхой хэсгийг нь хэрэгжүүлэхээр муу төлөвлөлт хийж байж болох юм.

График 23. БГД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор




График 24. БГД төсөл хэрэгжүүлэгч, насаар




График 25. БГД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр




График 26. БГД ажлын байрны мэдээлэл




График 27. БГД бизнесийн туршлага




График 28. БГД ХБ-ийн төрлөөр




График 29. БГД ХБ-ийн шалтгаанаар




График 30. БГД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр




График 31. БЗД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор




График 32. БЗД төсөл хэрэгжүүлэгч, насаар




График 33. БЗД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр




График 34. БЗД ажлын байрны мэдээлэл




График 35. БЗД бизнесийн туршлага




График 36. БЗД ХБ-ийн төрлөөр




График 37. БЗД ХБ-ийн шалтгаанаар




График 38. БЗД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр




График 39. СБД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор




График 40. СБД төсөл хэрэгжүүлэгч, насаар




График 41. СБД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр




График 42. СБД ажлын байрны мэдээлэл




График 43. СБД бизнесийн туршлага




График 44. СБД ХБ-ийн төрлөөр




График 45. СБД ХБ-ийн шалтгаанаар




График 46. СБД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр



График 47. СХД төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор




График 48. СХД төсөл хэрэгжүүлэгч, насаар




График 49. СХД төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр




График 50. СХД ажлын байрны мэдээлэл



График 51. СХД бизнесийн туршлага




График 52. СХД ХБ-ийн төрлөөр




График 53. СХД ХБ-ийн шалтгаанаар




График 54. СХД төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр




График 55. ДГА төсөл хэрэгжүүлэгч, боловсролоор




График 56. ДГА төсөл хэрэгжүүлэгч, насаар



График 57. ДГА төсөл хэрэгжүүлэгч, хүйсээр



График 58. ДГА ажлын байрны мэдээлэл



График 59. ДГА бизнесийн туршлага




График 60. ДГА ХБ-ийн төрлөөр





График 61. ДГА ХБ-ийн шалтгаанаар



График 62. ДГА төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагааны чиглэлээр



Мэдээлэл цуглуулсан 6 цэгүүдээс санхүүжилт хүссэн болон олгосон дүнг харвал бүгд 2022, 2023 онуудад иргэдийн хүссэн хэмжээнээс бага санхүүжилт олгосоор байна. Дээрх цэгүүд нь бусад аймаг, дүүргүүдтэй харьцуулахад хүн ам ихтэй ба ялангуяа нийслэлийн 3 том дүүргүүд шилжин суурьшигчид ихтэй учир хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэд төсөл ирүүлдэг байна. Иймээс ХХҮХ нь аль болох олон төслүүдийг дэмжихийг зорьж санхүүжилтийг багаар олон хүнд хүртээх байдлаар шийдэж байна.

Гэхдээ жилийн эцэст ХЭДС үргэлж төсвийн үлдэгдэлтэй байж, бүрэн зарцуулж чадахгүй байгаа нь бусад хөтөлбөр, арга хэмжээнүүдийн гүйцэтгэл бүрэн хангалттай биш байгаа учраас үлдэгдэлтэй байдаг байна.

Хүснэгт 6. БГД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн

Баянгол дүүрэг	2022			2023		
	Иргэн	Хүссэн дэмжлэг	Олгосон дэмжлэг	Иргэн	Хүссэн дэмжлэг	Олгосон дэмжлэг
Хүссэн хэмжээний дэмжлэг олгосон	58	25%	335,000,000	17%	335,000,000	28%
Хүссэн хэмжээнээс бага дэмжлэг олгосон	172	75%	1,694,685,650	83%	850,000,000	72%
Нийт	230		2,029,685,650		1,185,000,000	
				223	1,965,015,400	81%
						29%
						71%

Хүснэгт 7. БЗД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн

Баянзүрх дүүрэг	2022			2023		
	Иргэн	Хүссэн дэмжлэг	Олгосон дэмжлэг	Иргэн	Хүссэн дэмжлэг	Олгосон дэмжлэг
Хүссэн хэмжээний дэмжлэг олгосон	127	71%	1,010,000,000	68%	1,010,000,000	83%
Хүссэн хэмжээнээс бага дэмжлэг олгосон	51	29%	470,662,500	32%	200,000,000	17%
Нийт	178		1,480,662,500		1,210,000,000	
				130	1,045,000,000	68%
						84%
				50	482,044,000	32%
						16%

Хүснэгт 8. СБД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн

Сүхбаатар дүүрэг	2022						2023					
	Иргэн		Хүссэн дэмжлэг		Олгосон дэмжлэг		Иргэн		Хүссэн дэмжлэг		Олгосон дэмжлэг	
Хүссэн хэмжээний дэмжлэг олгосон	91	61%	666,000,000	57%	666,000,000	75%	106	73%	810,000,000	69%	810,000,000	82%
Хүссэн хэмжээнээс бага дэмжлэг олгосон	58	39%	500,655,900	43%	223,227,000	25%	40	27%	365,000,000	31%	176,707,700	18%
Нийт	149		1,166,655,900		889,227,000		146		1,175,000,000		986,707,700	

Хүснэгт 9. СХД-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн

Сонгинохайрхан дүүрэг	2022						2023					
	Иргэн		Хүссэн дэмжлэг		Олгосон дэмжлэг		Иргэн		Хүссэн дэмжлэг		Олгосон дэмжлэг	
Хүссэн хэмжээний дэмжлэг олгосон	105	44%	808,500,000	39%	808,500,000	58%	73	29%	496,000,000	22%	496,000,000	35%
Хүссэн хэмжээнээс бага дэмжлэг олгосон	131	56%	1,290,868,468	61%	579,000,000	42%	182	71%	1,769,990,000	78%	927,500,000	65%
Нийт	236		2,099,368,468		1,387,500,000		255		2,265,990,000		1,423,500,000	

Хүснэгт 10. ДГА-хүсэлт гаргасан хэмжээ ба олгосон дүн

Дорноговь аймаг	2022						2023					
	Иргэн		Хүссэн дэмжлэг		Олгосон дэмжлэг		Иргэн		Хүссэн дэмжлэг		Олгосон дэмжлэг	
Хүссэн хэмжээний дэмжлэг олгосон	82	84%	588,698,500	79%	588,698,500	89%	78	83%	568,900,000	79%	568,900,000	89%
Хүссэн хэмжээнээс бага дэмжлэг олгосон	16	16%	155,000,000	21%	72,000,000	11%	16	17%	154,500,000	21%	72,000,000	11%
Нийт	98		743,698,500		660,698,500		94		723,400,000		640,900,000	

Шигтгээ 3. Мэдээлэл цуглуулах явцад ХХҮГ/Х-ийн мэргэжилтнүүдээс авсан ярилцлага

ХХҮГ/Х-үүд нь санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан иргэний хүссэн дэмжлэгээс бага өгч байгаа нийтлэг шалтгаан нь хуваарилсан санхүүжилтийн хэмжээнээс шалтгаалан аль болох олон хүнийг хамруулах, төсөл хэрэгжүүлэгчийн ажлын цар хүрээ, бий болж байгаа ажлын байр, төслийн үр ашгийн тооцоо, дэмжлэгийн зарцуулалт гэх зэрэг байна.

Хүснэгт 11. БГД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл

Баянгол		2022		2023	
Ангилал	Хоног	Иргэн	СД-ийн дүн	Иргэн	СД-ийн дүн
Төлж дууссан		19	-	-	-
Хэвийн	15	56	79,100,498	91	278,878,920
Хугацаа хэтэрсэн	16-90	31	40,634,992	21	81,001,000
Хэвийн бус	91-180	22	47,687,000	27	106,654,000
Эргэлзээтэй	181-360	29	77,768,192	60	265,164,500
Муу	361+	73	320,119,969	24	147,878,000
нийт		230	565,310,651	223	879,576,420

Хүснэгт 12. БЗД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл

Баянзүрх		2022		2023	
Ангилал	Хоног	Иргэн	СД-ийн дүн	Иргэн	СД-ийн дүн
Төлж дууссан		21	-	-	-
Хэвийн	15	36	54,692,500	91	345,162,500
Хугацаа хэтэрсэн	16-90	11	23,279,000	14	65,749,000
Хэвийн бус	91-180	14	33,958,750	19	119,523,500
Эргэлзээтэй	181-360	19	71,300,750	49	321,188,750
Муу	361+	76	547,236,750	7	58,950,000
нийт		177	730,467,750	180	910,573,750

Хүснэгт 13. СБД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл

Сүхбаатар		2022		2023	
Ангилал	Хоног	Иргэн	СД-ийн дүн	Иргэн	СД-ийн дүн
Төлж дууссан		37	-	-	-
Хэвийн	15	40	66,401,367	87	297,788,546
Хугацаа хэтэрсэн	16-90	7	6,400,507	16	64,970,000
Хэвийн бус	91-180	11	21,815,058	16	80,712,700
Эргэлзээтэй	181-360	15	40,314,226	23	159,120,000
Муу	361+	40	224,560,380	4	22,630,000
нийт		150	359,491,538	146	625,221,246

Хүснэгт 14. СХД-хугацаа хэтрэлтийн мэдээлэл

Сонгинохайрхан		2022		2023	
Ангилал	Хоног	Иргэн	СД-ийн дүн	Иргэн	СД-ийн дүн
Төлж дууссан		30	-	5	-
Хэвийн	15	40	55,378,363	106	341,861,352
Хугацаа хэтэрсэн	16-90	15	27,830,110	19	86,167,336
Хэвийн бус	91-180	13	23,805,200	18	85,609,000
Эргэлзээтэй	181-360	24	63,226,147	58	300,629,040
Муу	361+	113	654,311,976	49	214,507,047
нийт		235	824,551,796	255	1,028,773,775

Хүснэгт 15. ДГА-хугацаа хэтрэлтийн мэдээлэл

Дорноговь		2022		2023	
Ангилал	Хоног	Иргэн	СД-ийн дүн	Иргэн	СД-ийн дүн
Төлж дууссан		11	-	4	-
Хэвийн	15	15	29,240,500	47	213,353,180
Хугацаа хэтэрсэн	16-90	7	10,300,000	8	40,209,000
Хэвийн бус	91-180	8	21,130,000	12	65,219,000
Эргэлзээтэй	181-360	20	70,199,000	20	108,370,068
Муу	361+	37	244,326,500	3	24,720,000
нийт		98	375,196,000	94	451,871,248

Хугацаа хэтрэлтийн мэдээллийг харвал өнгөрсөн 2 жилд дэмжлэгийн мөнгөө бүрэн буцааж төлсөн иргэн маш цөөн байгаа бол харин эргэлцээтэй, муу төлөвтэй төсөл хэрэгжүүлэгчдийн маш өндөр байгаа нь анхнаасаа олгож буй төслүүд нь төсөвлөлт, төлөвлөгөө муу, сул санаанууд ихээр дэмжигдэж мөн хэрэгжилтийн явцад мөнгөн бус дэмжлэг дутагдаж байгааг харуулж байна.

2.6.Эргэн төлөгдөхгүй санхүүгийн дэмжлэгт 2022-2023 онд шалгарсан төслийн болон төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

График 63. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан багийн гишүүдийн тоо, нас, хүйсээр




График 64. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан багийн гишүүд, боловсролоор




График 65. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан багийн гишүүд, мэргэжлээр




График 66. Шилдэг гарааны бизнест үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан баг, үйл ажиллагааны чиглэлээр



Нэгдсэн удирдамжид заасны дагуу Улаанбаатар хотод Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, аймагт аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь тухайн жилдээ мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гарааны бизнес санааг баяжуулж, өрсөлдүүлэх, бүлгээр ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах, шалгарсан “Старт ап”-ын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг зохион байгуулдаг.

Нийт санхүүгийн дэмжлэг авсан багийн гишүүдийн хувьд 17-24 насны залуучууд 45 хувь, 25-34 насны залуучууд 55 хувь, хүйсийн хувьд 61 хувь нь эрэгтэй, 39 хувь нь эмэгтэй байна. Мөн 80 хувь бакалавр, 13 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол 25 хувь нь мэдээлэл технологийн чиглэлийн мэргэжилтэй залууч байна. Үйл ажиллагааны чиглэл нь техник технологи, инноваци 47 хувь, үйлдвэрлэл 44 хувь, үйлчилгээ 8 хувийг эзэлж байна. Техник технологийн чиглэлийн төслүүд нь апп, вэб хөгжүүлэлт, үйлдвэрлэл нь бэлэг дурсгал, гоо сайхан, тавилга, төмөр хийц, хуванцар, цаасан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь аялал жуулчлал, эрүүл мэнд, түрээс багтаж байна.

2.7. Санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах нэгдсэн удирдамжид зааснаар санхүүгийн бус дэмжлэгийг дараах байдлаар үзүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 16. Санхүүгийн бус дэмжлэгийн мэдээлэл

Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах	Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх болон олгосны дараах сургалтыг зохион байгуулах ба иргэн, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн мэдлэг олгох, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх тухай сургалтыг зохион байгуулах
Борлуулалтын цэг ажиллуулах, үзэсгэлэн, яармаг зохион байгуулах	Жижиг зээл, санхүүгийн болон бусад дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт борлуулалтын цэг ажиллуулах, улсын хэмжээнд хамгийн өндөр ашиглалт хандалттай 2 хүртэлх хувийн хэвшлийн худалдааны цахим хуудастай хамтарч ажиллах
Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, ХЭДС-аас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, газар дээрх нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны төлбөрийн хөнгөлөлтийг төлбөр төлсөн баримтын дүнгээр нөхөн олгох
Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт, туршлага солилцох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах

Хүснэгт 17. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан байдал (зээлийн өмнөх)

Он	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл			Нийт СД-т хамрагдах хүсэлт гаргасан хүн	Санхүүгийн бус дэмжлэгт хамрагдсан хүн		Гүйцэтгэл /хүнээр/
	Хүн	Дүн	Хүн	Дүн	Хувь		Хүн	Хувь	
2022	775	13,409,000	680	11,810,000	88	1,887	680	36	
2023	965	27,665,000	964	27,648,000	100	1,598	964	60	
Нийт	1,740	41,074,000	1,644	39,458,000	96	3,485	1,644	47	

Хүснэгт 18. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан байдал (зээлийн дараах)

Он	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл			Нийт СД-т хамрагдсан хүн	Санхүүгийн бус дэмжлэгт хамрагдсан хүн		Гүйцэтгэл /хүнээр/	
	Хүн	Дүн	Хүн	Дүн	Хувь		Хүн	Хувь		
2022	725	19,835,000	655	17,679,000	89	891	655	74		
2023	380	11,025,000	379	10,815,000	98	898	379	42		
Нийт	1,105	30,860,000	1,034	28,494,000	92	1,789	1,034	58		

Хүснэгт 19. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан байдал

Он	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл			Нийт СД-т хамрагдсан хүн	Санхүүгийн бус дэмжлэгт хамрагдсан хүн		Гүйцэтгэл /хүнээр/	
	Хүн	Дүн	Хүн	Дүн	Хувь		Хүн	Хувь		
2022	453	543,600,000	124	177,420,000	33	649	124	19		
2023	338	414,000,000	128	207,261,450	50	654	128	20		
Нийт	791	957,600,000	252	384,681,450	40	1,303	252	19		

Хүснэгт 20. Борлуулалтын дэмжлэгийн гүйцэтгэл

	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл %
2022	134,500,000	96,360,531	72
2023	144,500,000	64,750,419	45
Нийт	279,000,000	161,110,950	58

Нийт хүсэлт гаргаж төсөл ирүүлсэн иргэдийн 47 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалтын зээлийн өмнөх сургалтад хамрагдсан бол нийт дэмжигдсэн 1,789 иргэний 58 хувь зээлийн дараах сургалтад хамрагдсан байна. Санхүүгийн бус дэмжлэгийн төрөл болох аж ахуй эрхлэлтийн сургалтыг хуваарилагдсан төсвийн дагуу зарцуулдаг хэдий ч нийт санхүүгийн дэмжлэг хүссэн болон дэмжлэг авсан иргэдийн хувьд хүртээмж 52 хувьтай байна.

Харин түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийн хувьд хуваарилагдсан төсвөөс дундажаар 40 хувь нь зарцуулагдаж байгаа нь 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа дэмжлэг авсан иргэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн баримтыг үндэслэн олгох гэсэн шаардлагыг бүрэн хангаж чаддаггүйгэй холбоотой.

Мөн борлуулалтын дэмжлэгийг нэгдсэн удирдамжид заасны дагуу санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор борлуулалтын цэг ажиллуулах, үзэсгэлэн, яармаг зохион байгуулж оролцуулах хэлбэрээр нийтлэг зохион байгуулж байна.

2.8. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал

Аймаг, дүүргийн ХХҮГ/Х нь хяналт шалгалтын удирдамж, хуваарь батлуулан сум, хороодод ажиллаж хяналтын ажлыг нийтлэг байдлаар зохион байгуулсан байна. Мөн эргэн төлөлтийн графикийн дагуу төлөлт хийгдэж байгаа эсэх болон хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийг шүүхийн байгууллагад шилжүүлэх, дэмжлэг авахаас өмнөх болон дараах сургалтад хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

Хяналт, шалгалтын мөрөөр хариуцсан хэлтэс, алба, мэргэжилтэнд хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Шигтгээ 4. Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Доржсугарын ажлын зохион байгуулалт

Тухайн жилийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж эхлэхээс өмнө төсөл, хөтөлбөр, санхүүгийн дэмжлэгийг журам, удирдамжийн дагуу хэрхэн зохион байгуулах тал дээр нэг бүрчлэн зөвлөмжийг гаргаж, зохион байгуулах хэлтэс, алба, мэргэжилтэнд хүргүүлдэг байна. Ингэснээр анхан шатанд зохион байгуулж байгаа албан хаагчдад ажлын зохион байгуулалтыг зөв зохистой, үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг болжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ

- ХЭДС-ын 59 хувийг жижиг, зээл, санхүүгийн дэмжлэгийг олгоход зориулан төлөвлөж буй атал эдгээр шинэ болон өргөжин тэлж буй бизнесийг дэмжих тал дээр аж ахуй эрхлэлтийн сургалт, борлуулалтын болон түрээсийн төлбөрийн дэмжлэгээс өөр санхүүгийн бус зөвлөх үйлчилгээ, бойжуулах үйлчилгээнд төсөв хангалттай хуваарилахгүй байгаа нь дэмжлэг авсан төслүүдийг бүрэн дэмжилгүй орхиж, бүтэлгүйтэх магадлалыг нэмэгдүүлж байна.
- Санхүүгийн дэмжлэг олгох ажлыг зохион байгуулах үйл явц нь дээд удирдлага болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргаж өгсөн удирдамж, чиглэлийн дагуу зохион байгуулагдаж байгаа хэдий ч аймаг, дүүргийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг төслийн материал хүлээн авахад тавигдах шаардлага, баримт бичгийн жагсаалт зэргийг шийдэж байгаа нь өмнөх санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт эрсдэлтэй байсан тул түүнээс сэргийлэх үүднээс нэмэлт материалууд шаардаж байна.
Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүд нь дээрээс өгсөн Нэгдсэн удирдамж болон журмын шаардлагаас гадна 1-7 хүртэлх нэмэлт баримтуудыг нэмж иргэдээс шаардаж байгаа нь хүсэлт гаргасан иргэдийн санхүүгийн чадавхи, зээлжих чадавхийг харах, баталгаа авах, үнэлгээ хийхэд хангалттай мэдээлэл цуглуулах зорилгоор авч байгаа хэдий ч энэ нь сайн төслүүдийг шалгаруулахад төдийлөн нөлөө үзүүлэхгүй байна.
- Бодлого, арга хэмжээ, удирдамж ямар батлагдана яг түүгээрээ анхан шатны нэгж дээр хэрэгждэг. Гэхдээ ирүүлсэн төслийг хэрхэн үнэлэх, сонгон шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг хэмжих тал дээр дэлгэрэнгүй, тодорхой чиглэл, зөвлөмж байдаггүйн улмаас бодит байдал дээр эрсдэл өндөр бизнесүүд дэмжлэг авах, олгосон нэгжүүд эргээд үр дүнгээ тооцох, эргэн төлөлтөө олж авах тал дээр асуудлууд үүссээр байна.
- Зохицуулалтын журмуудад жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад голлон анхаарсан бол харин санхүүгийн бус дэмжлэг, сургалт, аргагүйн зөвлөгөө зэрэг бизнесийг амжилттай хэрэгжихэд чухал нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдийг орхигдуулсан.
- Иргэдийн бүрдүүлэх баримт бичигт төсөл, төлөвлөгөө гэж заасан нь хүсэлт өгч буй иргэдийн хувьд ч тэр хүлээж авч үнэлэх ажлын хэсгийн хувьд ч анхаарвал зохих гол асуудал болж байна. Санхүүгийн дэмжлэг авах хүсэлтэй иргэд нэг өдрийн сургалтад хамрагдаж хэрхэн төсөл бичих талаар анхны ойлголт, мэдээлэл авдаг. Гэхдээ зарим иргэд төслүүдээ ямар нэг өөр мэргэжилтэн,

эсвэл байгууллагаар бэлтгүүлэн бичүүлдэг тохиолдол байсаар байна. Бизнес эрхлэх ямар нэгэн туршлагатай анх эхэлж буй иргэдийн хувьд төсөл, төлөвлөгөө боловсруулах нь хүндрэлтэй байдаг ба энэ “төсөл, төлөвлөгөө” ямар бүтэц, агуулгатай байх талаар, жишиг загвар, чиглүүлэг байдаггүй ба тухайн сургалт зохион байгуулж буй сургалтын байгууллага өөрсдийн гаргасан сургалтын хөтөлбөрийн дагуу харилцан адилгүй зохион байгуулж байна.

- Дээрх дүүрэг, аймагт ажиллаж, мэдээлэл цуглуулах явцад ХЭДС-аас олгож буй санхүүгийн дэмжлэгийг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс харахад асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс бүрдсэн байсан. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчид буюу нийгмийн үйлчилгээний чиг үүрэгтэй, туршлагатай хүмүүсээс бүрдсэн байгаа нь төсөл шалгаруулах үнэлгээг гүйцэтгэхэд төдийлөн оновчтой бус байна. ХХҮХ/Г-т ажиллаж буй хүмүүсийн судалгаанаас харахад бизнесийн чиглэлээр мэргэшсэн хүн байдаггүй ба мэргэжилтнүүдийн 40 гаруй хувь нь уг албан тушаалдаа 1 хүрэхгүй жил ажилласан байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажиллагсдын дунд тогтвортой ажиллах хүчин бага байгааг харуулахаас гадна, хувиараа хөдөлмөр эрхлэхээр төрөөс дэмжлэг хүсэж буй иргэдийн чадавхийг үнэн зөв үнэлж, дэмжлэг олгох гэхээсээ илүү шаардлагад нийцсэн баримт бичиг ирүүлсэн эсэхэд үнэлгээ өгч шалгаруулж байна гэж хэлж болохоор байна.
- Төсөл шалгаруулах ажлын хэсэг төслийг хэрхэн ямар аргачлал, оноо өгч үнэлдэг мөн татгалзсан шалтгааны талаар мэдээлэл хомс байна. Төсөл олгохоос татгалзсан нийтлэг шалтгаан нь ажлын байр байхгүй, өөр хүний ажлын байр үзүүлсэн, төсөл шаардлага хангаагүй, бусад төсөлд давхар хамрагдсан, иргэн өөрөө шаардлага хангаагүй гэсэн тайлбарыг өгч байсан. Хассан шалтгааныг зарим ажлын хэсэг бүрэн бүртгэж, тэмдэглэл хөтөлдөггүй байна.
- Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн төслийн үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл сүүлийн 2 жилийн хугацаанд боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр санхүүгийн дэмжлэг хүссэн иргэд зонхилж байсан ба хөдөө аж ахуйн чиглэлийн хүсэлт удаалж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс санхүүгийн дэмжлэг, жижиг зээл олгох эдийн засгийн чиглэлийг нарийвчлан заадаггүй ерөнхий мэдээлэл өгдөг учир иргэд өөрсдийн сонирхсон, туршлагажсан чиглэлээрээ ямар нэгэн зах зээлийн судалгаа, эрэлт зэргийг тооцоололгүйгээр төсөл бичиж байна.
- Санхүүгийн дэмжлэг авснаар бий болсон болон хадгалагдаж буй ажлын байрны мэдээллийг харахад ихэнх нь тухайн ажлын байраа хадгалж үлдэх үйл ажиллагаагаа тасалдуулахгүй үргэлжлүүлэхэд зарцуулж байгаа бол талаас бага хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн шинэ ажлын байр гаргаж чадаж байна.
- Түүнчлэн санхүүжилт авсан иргэдийн 55 хувь нь 5 хүртэл жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай буюу шинээр эхлээд удаагүй байгаа төслүүд байсан бол ажилласан жил нэмэгдэх тусам дэмжлэг авах нь бага болж байгаа нь биеэ дааж, бизнес нь жигдэрсэн иргэдэд ХЭДС-ын дэмжлэг төдийлөн шаардлагатай бус болохыг харуулж байна.
- Дэмжлэг авсан төслүүдийн дийлэнх нь тоног төхөөрөмж түүхий эд авах, бүтээгдэхүүнээ өргөжүүлэх зэрэг нийт төслийн зөвхөн тодорхой нэг хэсгийг л санхүүжүүлэхээр хүсэлт гаргаж байгаа нь иргэдийн гаргасан санаачилгыг бүхэлд нь санхүүжүүлж хүрэхгүй зөвхөн нэгэн хэсэгт зарцуулагдаж байгааг харж болохоор байна. Үүнээс хоёр дүгнэлтийг хийж болох ба 1-т Санхүүжилтийн батлагдсан дээд дүн иргэдийн хэрэгцээг хангалттай санхүүжүүлж хүрэлцэхгүй байгаа эсвэл 2-т иргэд санхүүгийн мэдлэг муу учраас нийт санхүүжилтээ зөвхөн тодорхой хэсгийг нь хэрэгжүүлэхээр муу төлөвлөлт хийж төсөл бичсэн харагдаж байна.
- 2022, 2023 онуудад иргэдийн хүссэн хэмжээнээс бага санхүүжилт олгосон ба судалгаанд хамрагдсан дүүргүүд нь бусад аймаг, дүүргүүдтэй харьцуулахад хүн ам ихтэй ба ялангуяа нийслэлийн 3 том дүүргүүд шилжин суурьшигчид ихтэй учир хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэд төсөл ирүүлдэг байна. Иймээс ХХҮХ нь аль болох олон төслүүдийг дэмжихийг зорьж санхүүжилтийг багаар олон хүнд хүртээх байдлаар шийдэж байна.

ЗӨВЛӨМЖ

Сургалт. Судалгаанаас харахад хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлт гаргаж буй иргэдийн бодит хэрэгцээг зөв үнэлэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Иргэдийн санал болгож буй төсөл нь ерөнхийдөө тоног төхөөрөмж, түүхий эд авах зорилгоор бичигдэж буй нь бизнесээ амжилттай болгох, өргөжүүлэхэд хангалттай дэмжлэг болж чадахгүй байна. Тиймээс иргэдэд төсөл боловсруулахаас өмнө 3 өдрийн сургалтын агуулгыг сайжруулж, хугацааг 5-7 хоног болгосноор иргэд өөрийн бизнестээ хэрэгтэй байгаа зүйлээ бүрэн судалж, суралцах боломж бүрдэнэ.

Ментор, инкубацийн үйлчилгээ. Иргэд санхүүгийн дэмжлэгээ эргэн төлж чадахгүй байгаа нь уг төсөл амжилттай хэрэгжээгүйг харуулж буй томоохон үзүүлэлт юм. Тиймээс санхүүгийн дэмжлэг олгож эхэлсэн цагаас эхлэн тухайн иргэнд чиглүүлэгч (бизнесийн ментор) эсвэл зөвлөх баг (мэргэшсэн гэрээт байгууллага) томилж 6-12 сарын хугацаанд хамт ажиллуулах нь зүйтэй байна. Уг чиглүүлэгч эсвэл мэргэшсэн багийн зардлыг ХЭДС-ын төсөвт суулган, жишиг зардалд оруулснаар хэрэгжүүлэх боломжтой.

Үнэлгээ. Одоогийн тогтолцоогоор аймаг, дүүргийн ХХҮГ/Х нь бизнесийн ур чадвар болон зээлжих чадварын үнэлгээг өөрсдийн хэмжээнд тухайн иргэний холбогдох баримт бичиг, ажлын байр зэргийг харснаараа буюу үзэмжээрээ үнэлж байна. Энэ арга нь үр дүн муутай, эрсдэлтэй судалгааны дата харуулж байна. Тиймээс энэ чиг үүргийг мэргэжилтнүүдийн чиг үүргээс авч мэргэжлийн байгууллагаар үнэлгээг гүйцэтгүүлэх, эсвэл цахим системийн (жишээ нь киоск) аргаар иргэний мэдээлэл, түүхт шинжилгээ хийх замаар тодорхойлдог алхмыг нэвтрүүлэх боломжтой юм. Ажлын даалгаварт дурдсан EQ+AQ+MBTI зэрэг бизнесийн ур чадварыг тодорхойлох аргуудыг цахим платформ эсвэл, зээлийн аппликейшний зарчмуудын адилаар төрийн мэдээллүүдийг татан шинжилж нэвтрүүлэх боломжтой юм.

Бүртгэл, мэдээллийг сайжруулах. Зээл авсан болон санхүүгийн дэмжлэг авах хүсэлт гаргасан, авсан иргэдийн мэдээлэл түүхийг цахим бүртгэлд бүрэн оруулж тогтмол шинэчлэх, алдааг байнга шалгаж засварлах шаардлагатай байна. Энэ тал дээр аргагүй боловсруулж, удирдамж гаргах, сургалт зохион байгуулах зэргээр мэргэжилтнүүдийг и-жоб цахим платформ дээр мэргэшүүлж болно. Байнгын, цаг үеийн шинэ мэдээ мэдээлэл, тайлан гаргаж байх нэн шаардлагатай байна.

Бусад. Зохион байгуулж буй ХХҮГ/Х нь харилцан бие биенээсээ туршлага судлах, сайн жишээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Жишээ нь Дорноговь аймгийн ХХҮГ нь аж ахуйн эрхлэлтийн сургалтад хамруулж, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх ажлыг маш сайн зохион байгуулсан бол Баянгол дүүргийн ХХҮХ нь төсөл сонгон шалгаруулалтын үнэлгээг ил тод, бодит, тодорхой үнэлж ажилласан байсан. Мөн Сонгинохайрхан, Баянгол дүүргийн ХХҮХ нь санхүүжилт хүссэн иргэдийн тооноос шалтгаалан санхүүгийн дэмжлэгийг хүртээмжтэй байдлаар шийдвэрлэсэн бол Баянзүрх дүүргийн ХХҮХ нь хүссэн санхүүжилтийг төсөл сонгон шалгаруулалтын үр дүнд үндэслэн хүссэн хэмжээгээр олгоход анхаарч ажилласан. Харин Сүхбаатар дүүргийн ХХҮХ нь санхүүжилт олгохоос өмнө болон олгосны дараах хяналт, үнэлгээ, зөвлөмжийг хангалттай хэмжээнд өгч, төсөл хэрэгжүүлэгчийн мэдээллийг анкетаар бүрэн цуглуулж, төслийн стандарт болон бичиг баримтын бүрдлийг баримталж ажилласан байна.

НОМ ЗҮЙ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
2022, 2023 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээ

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс
Архивын цаасан болон цахим баримт
Төсвийн 2022-2023 оны гүйцэтгэлийн мэдээ
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн програм
Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг нэгдсэн систем office.ejob.gov.mn/login
Халамжийн нэгдсэн систем <https://ehalamj.mn/login>

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=563>
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=202957>
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=202958>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны нөлөөллийг үнэлэх судалгаа (2023)
<https://sudalгаа.gov.mn/pdf/vPbkYY>

UNDP, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ (2023)
https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2023-06/khodolmor_erkhleltiyg_demzhikh_khotolboriyn_aguulga_ur_dungiyn_unelgee_2023.pdf

Сангийн яам, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тэмдэглэл (2018)
https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/3_%20%D0%A8%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-%D0%A5%D0%AD%D0%94%D0%A1.pdf

UNDP, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдал хийсэн дүн шинжилгээ (2022)
https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2023-01/Employment%20Promotion%20Policy%2C%20Measures%2C%20and%20Analysis%20of%20the%20Current%20State%20of%20Financing_MON.pdf